

МОНГОЛЬСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт истории и
этнологии

МЕЖДУНАРОДНАЯ
АССОЦИАЦИЯ
МОНГОЛОВЕДОВ

РОССИЙСКАЯ
АКАДЕМИЯ НАУК
Институт восточных
рукописей



КУЛЬТУРНОЕ НАСЛЕДИЕ МОНГОЛОВ: КОЛЛЕКЦИИ РУКОПИСЕЙ И АРХИВНЫХ ДОКУМЕНТОВ

IV

**Международная конференция
при поддержке Президента Монголии**



18-19 апреля, 2019. Улан-Батор

Сборник докладов

Санкт-Петербург — Улан-Батор
2021

ННА 63.4
ДAA 930.1
М-694

Ответственный редактор:	Академик С.Чулуун
Научные редакторы:	доктор филол. наук И.В.Кульганек Ph.D Н.Хишигт
Редакторы, составители:	Ph.D Б.Нацагдорж канд. филол. наук. Н.С.Яхонтова

Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов. Сборник докладов IV международной научной конференции. 18—19 апреля 2019 г. Улан-Батор. Россия. СПб.—УБ. 2021 г. —276 с.,

Сборник представляет собой собрание докладов IV международной научной конференции “Культурное наследие монголов: коллекции рукописей и архивных документов”, организованной Институтом истории и археологии МАН, Ассоциацией международных монголоведов и Институтом восточных рукописей РАН в г. Улан-Батор, 18—19 апреля 2019 г.

Основой для конференции стали рукописные фонды и архивы, хранящие документы и материалы по истории, культуре, этнографии, политике, языку монгольских народов. В сборнике публикуются доклады, освещающие историю монголоведения, а также доклады, посвященные рукописным материалам о материальной культуре монголов, их письменному наследию, художественному творчеству, экспедициям и разным сторонам жизни традиционного и современного монгольского общества.

ISBN 978-9919-9646-7-2
DOI 10.25882/z7ch-tr43

© Институт истории и этнологии МАН, 2021 г.
© Институт восточных рукописей РАН, 2021 г.
© Международная ассоциация монголоведов, 2021 г.

МОНГОЛ УЛСЫН
ШИНЖЛЭХ УХААНЫ
АКАДЕМИ
Түүх, угсаатны зүйн
хүрээлэн



ОЛОН УЛСЫН
МОНГОЛ СУДЛАЛЫН
ХОЛБОО



ОРОСЫН ШИНЖЛЭХ
УХААНЫ АКАДЕМИ
Дорно дахины гар
бичмэлийн хүрээлэн



МОНГОЛЧУУДЫН СОЁЛЫН ӨВ: ГАР БИЧМЭЛ БА АРХИВЫН БАРИМТЫН ЦУГЛУУЛГА

IV

Монгол улсын ерөнхийлөгчийн ивээл дор
зохион байгуулсан



Олон улсын эрдэм шинжилгээний хурал

2019 оны 4 сарын 18-19
Монгол улсын Улаанбаатар хот

Илтгэлүүдийн эмхэтгэл

Санкт-Петербург - Улаанбаатар
2021

ННА 63.4
ДАА 930.1
М-694

Хариуцлагатай редактор: Академич С.Чулуун

Эрдэм шинжилгээний редактор:

Хэл бичгийн ухааны доктор И.В.Кульганек

Түүхийн ухааны доктор (Ph.D) Н.Хишигт

Редактор, эмхэтгэгчид:

Түүхийн ухааны доктор (Ph.D) Б.Нацагдорж

Хэлшинжлэлийн дэд эрдэмтэн Н.С.Яхонтова

Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга

- IV. Олон улсын эрдэм шинжилгээний хурлын илтгэлүүдийн эмхэтгэл. Монгол улс, Улаанбаатар хот. 2019 оны 4 дүгээр сарын 18-19. Санкт-Петербург-Улаанбаатар., 2019 г. 276 тал.

Монгол улсын ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэн, Оросын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн болон Олон Улсын Монгол судлалын холбооноос 2019 оны 4 дүгээр сарын 18-19-нд Монгол улсын Улаанбаатар хотноо “Монголчуудын соёлын өв: гар бичмэл ба архивын баримтын цуглуулга” 4 дэх удаагийн олон улсын эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулав.

ОХУ, Монгол улсын гар бичмэлийн сан хөмрөг, архивуудад хадгалагдаж байгаа монгол угсаатан ард түмнүүдийн түүх, хэл, соёлын арвин баялаг эх сурвалж нь тус хурлын эх суурь болсон юм. Эмхэтгэлд монгол судлалын түүх, дэлхийн ба Монгол, Оросын шинжлэх ухааны байдал, монголчуудын эдийн соёл, бичгийн өв, уран сайхны бүтээл туурвил, Монголын уламжлалт болон орчин үеийн нийгмийн асуудлыг тусгасан гар бичмэл, баримт, эх хэрэглэгдэхүүнийг судлан шинжилсэн илтгэлүүд багтсан болно.

ISBN 978-9919-9646-7-2

DOI 10.25882/z7ch-tr43

© Монгол улсын ШУА-ийн Түүх, угсаатны зүйн хүрээлэн, 2021

© ОХУ-ын ШУА-ийн Дорно дахины гар бичмэлийн хүрээлэн, 2021.

© Олон улсын Монгол судлалын холбоо, 2021.

MONGOLIAN
ACADEMY OF
SCIENCES
Institute of History
and Ethnology



INTERNATIONAL
ASSOCIATION FOR
MONGOL STUDIES



RUSSIAN ACADEMY
OF SCIENCES
Institute of Oriental
Manuscripts



CULTURAL HERITAGE OF THE MONGOLS: MANUSCRIPT AND ARCHIVAL COLLECTIONS

IV

**International Conference
Under the Patronage of the President of Mongolia**



April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia

Proceedings

St. Petersburg — Ulaanbaatar
2021

ННА 63.4
ДAA 930.1
М-694

Managing Editor:	Academician S.Chuluun
Scientific Editors:	Dr.Sc. (Philology) I.V.Kulganek Ph.D (History) N.Khishigt
Editor, compiler:	Ph.D (History) B.Natsagdorj Cand. Sc. (Philology) N.S.Yakhontova

Cultural heritage of the Mongols: manuscripts and archival collections. Papers of the IV International Conference, April 18-19, 2019. Ulaanbaatar, Mongolia. St.Petersburg —Ulaanbaatar 2019, 276 pages.

This is a collection of papers, presented at the Fourth International Conference organized by the Institute of History and Archeology of the Mongolian Academy of Sciences, the Institute of Oriental Manuscripts of the Russian Academy of Sciences and the International Association for Mongol Studies which was held in Ulaanbaatar on April 18-19, 2019.

The basis for the conference was hand-written funds and archives, storing documents and materials on history, culture, ethnography, politics and language of the Mongolian peoples. The collection publishes reports on the history of Mongolian studies, as well as reports on handwritten material on the Mongolian culture, their written heritage, artistic creativity, expeditions and the problems of traditional and Modern Mongolian society.

ISBN 978-9919-9646-7-2
DOI 10.25882/z7ch-tr43

© Institute of History and Ethnology, MAS 2021
© Institute of Oriental Manuscripts, RAS 2021
© International Association for Mongol Studies, 2021

ГАРЧИГ / СОДЕРЖАНИЕ / CONTENT

Өмнөтгөл (С.Чулуун)	9
<i>Г.Ариунтуяа</i>	
Монгол Улсын Үндэсний Төв Архив дахь Ж.Цэвээний хувийн хөмрөг	11
<i>Д.Баярсайхан</i>	
Монголчуудын тухай XIII-XIV зууны Армян сурвалжийн тойм	23
<i>Ts.P.Vanchikova</i>	
Folklore Heritage of the Buryats in the Funds of the COMX and Problems of its Research and Conservation	35
<i>Ж.Гэрэлбадрах</i>	
Монгол Улсын Газар зохион байгуулалт, Геодези, Зурагзүйн газрын архивт буй нутгийн зургийн цуглуулга	43
<i>Л.С.Дампилова</i>	
Шаманские материалы в фонде Т.К.Алексеевой в ЦВРК ИМБТ СО РАН	57
<i>Ж.Долгорсүрэн</i>	
Эрдэмтэн, зохиолч, найруулагч, орчуулагч Э.Оюун: хэвлэгдээгүй гар бичмэл, намтрын баримтууд	65
<i>Г.А.Дыргеева</i>	
Традиционная письменная культура Бурят: социоллингвистический аспект	73
<i>Г.А.Гребенищикова</i>	
Монголия в планах Военного и Морского ведомств России в 1903-1913 годах	84
<i>В.Ю.Жуков, И.В.Кульганек</i>	
«История монголов» О.М.Ковалевского: первое прочтение	98
<i>И.М.Захарова, М.В.Мандрик</i>	
К вопросу о деятельности Советника при Монгольском правительстве П.А.Витте	107
<i>С.Мөнхсайхан</i>	
Уламжлалт монгол хэл зүйн бичгүүдийн хэл шинжлэлийн ач холбогдол хийгээд сурвалж бичгийн үнэ цэнэ	121
<i>Б.Нацагдорж</i>	
Тод үсгийн нэгэн захидлаас <i>Ойрад</i> хэмээх нэрийн тухай тодруулах нь	136

Д.А.Носов

Россыпи документов В.А.Казакевича: отчеты о поездках
по Монголии 1923—1925 гг. 149

К.В.Орлова

Документальное наследие калмыков: письма калмыцких ханов 160

Р.Ю.Почекаев

Суд и процесс в монгольских «Хождениях в ад» 167

Г.Сэр-Од

Монгол Улсын Үндэсний төв архивын сан хөмрөг дэх
Тамга, захирлага, тэмдгийн цуглуулга хөмрөг 176

М.В.Федорова

Монгольские фотоколлекции конца XIX — начала XX вв.
в собрании Российского этнографического музея, как источник
для изучения традиционной культуры монголов 186

Ц.Цэрэндорж

XV-XVIII зууны Солонгос сурвалж дахь Монголын түүхэнд
холбогдох мэдээ баримтаас 204

Д.Энхцэцэг

Монгол – Мингийн харилцаа: захидал бичгийн тухай 219

Ц.Энхчимэг

“Төмөрийн цаазын бичиг”: Монголын эзэнт гүрний түүхийн
чухал сурвалж болох нь 240

Н.С.Яхонтова

Аспиранты из Монголии в Академии наук 250

Сведения об авторах 268

Зохиогчдын танилцуулга 272

Д.Баярсайхан

МОНГОЛЧУУДЫН ТУХАЙ XIII-XIV ЗУУНЫ АРМЯН СУРВАЛЖИЙН ТОЙМ

DOI 10.25882/85cf-nb08

XIII-XIV зуун нь Армяны түүх бичлэгийн хамгийн баялаг оргил үе гэж үздэг. Энэ үед Самвел Анеци, Мхитар Анеци, Матеос Урхаеци, Мхитар Айриванеци, Вардан Аревелци, Киракос Гандзакеци, Григор Акнерци, Вахрам Рабуни, Смбат Спарамет, Хетум Патмич, Степанос Орбелиан зэрэг арав гаруй түүхч бүтээлээ туувивж үлдээжээ. Гэвч тэдний зохиолууд нь Их Армян юм уу эсхүл Киликийн Армян хаана зохиогдсоноосоо шалтгаалан монголчуудыг үзэх нь өөр өөр бөгөөд зохиогчийнх нь хувийн үзэлт болон хөндлөнгийн байр сууринаас бичигдсэн зэрэг янз бүр байх ажээ.

Түлхүүр үгс: монголчууд, Армян сурвалж, түүх бичлэг

D.Bayarsaikhan

SUMMARY OF THE ARMENIAN SOURCES OF THE 13-14TH CENTURIES ON MONGOLS

The thirteenth-fourteenth centuries formed one of the richest periods in Armenian historiography. It gave more than ten historians and chronologists, like Samuel Anets'i, Mkhit'ar Anets'i, Matheos Urhayets'i, Mkhit'ar Ayrivanets'i, Vardan Arevelts'i, Kirakos Gandzakets'i, Grigor Aknerts'i, Vahram Rabuni, Smbat Sparapet, Het'um Patmich', Step'annos Orbelian, and etc. However, Armenian sources for the Mongols differ in their attitudes towards the Mongols, expressing both neutral and personal views and depending on where they have been written, in Greater Armenia or in Cilician Armenia.

Keywords: Mongols, Armenian sources, Historiography

Армяны түүх бичлэг арвин уламжлалтай. Армянчуудын бичсэн түүхэн сурвалжийн оргил үе V зуун, улмаар XIII-XIV зуунд тохиосон гэж үзэж болно. V зуунд армянчууд бичиг үсэгтэй болсноороо түүхээ бичих их үйлсийг эхлүүлсэн байдаг бол XIII зуунд армян түүх бичлэг “эрийн цээнд” хүрсэн байдаг. Хачирхалтай нь энэ үе “монголын үе”-тэй давхацдаг хийгээд энд түүхчдийн бүтээлээс гадна он бичгийн дараалал, *агиографи* буюу шашны зүтгэлтнүүдийн намтар, *колофон* буюу төгсгөлийн үгс, чулуун дээрх бичээс хийгээд яруу найргийн бүтээлүүд олноор гарч ирсэн байна. Үүнийг тайлсан тайлбар байдаггүй ч монголчуудын нөлөө буюу шашны уян хатан бодлого гэж үзэж болно, учир нь монголчууд тухайн ард түмний бичиж байсан түүх, соёлын өвийг устгах зорилго тавиагүй бөгөөд тухайн нутгийн боловсролын төв болох христийн сүм хийд хийгээд лам нарын үйл ажиллагаанд шууд оролцож байгаагүй явдал юм.

Ганзакийн Киракос (Kirakos Ganjaketsi, 1200-1271), Зүүн нутгийн Вардан (Vardan Areveltsi, с. 1200-1271), Акнер сүмийн Григор (Grigor Aknerts'i, 1250-1335), Орбел овгийн Степанос (Step'annos Orbelian, 1250/60-1304) зэрэг түүхчид өөрсдийн бүтээлдээ Армян ард түмний олон зуун жилийн түүх дотор монголчуудын үеийг оролцуулан бичсэн байхад Корикосын Хетум буюу Хетум түүхчийн (Het'um of Korikos, с. 1240-с. 1310) *Татарчуудын түүх* хэмээх зохиолыг Ромын пап ламын ивээлд нийцэх зорилгоор бичсэн хэмээн үзэж болно.

Эл товч өгүүлэлд XIII-XIV зууны армян сурвалжийн онцлогийг төрөл тус бүрд нь авч үзэх ба монголчуудын тухай мэдээн дээр төвлөрөх болно.

Монголчуудын тухай армян сурвалжийг танилцуулахын өмнө армянчууд хаагуур нутаглаж байсан газрын зургийг авч үзэх хэрэгтэй. Их Армян (Greater Armenia), Бага Армян (Lesser Armenia), Киликийн Армян (Cilicia) гэсэн 3 хэсэг нутаг түүхэн газарзүйд өөр өөрийн байршилтай байсан¹. Монголчууд XIII зуунд энэ хязгаарт ирэх үед Кавказын нурууг дэрлэн орших Их Армян, Газар дундын тэнгисийн эрэг орчим байрших Киликийн Армян гэсэн 2 тусдаа армянчуудтай шууд холбогдсон юм. Киликийн Армяныг Бага Армян хэмээн нэрлэх нь буруу, учир нь газарзүйн байршлын хувьд 2 өөр байршилд 2 өөр цаг хугацаанд оршиж байсан нутгууд болохыг зургаас харж болно.

¹ Strabo, XI, XIV, 1969: 317-341; Hewsен, 1997: 1-17.



Армянчуудын түүхтэй холбоотой хэдэн зүйлийг тодруулбаас, Ассирийн эзэнт гүрний үед тэд Урарту хэмээх нэртэй уялдан гардаг ба энэ нь Арарат уулын нэршилтэй холбоотой. Библид гардаг Ной-ийн газарддаг уул нь Арарат юм². НТ 301 онд армянчууд зороастрын шүтлэгээсээ салж христ итгэлт улс болсон. 405 онд армян цагаан толгойг ламтан Месроп Маштоц грек цагаан толгойн зарчим дээр тулгуурлан зохиож армянчууд бичиг үсэгтэй ард түмэн болсон. Урт удаан түүхийн явцад армянчууд өрсөлдөгч эзэнт гүрнүүдийн уулзвар нутагт байрлаж байсны хувьд Ассири, Миди, Ахемен, Парфи, Византи, Сассан, Араб,

² Арарат уул нь Аракс гол (өнөөгийн Армян), Ван нуур (өнөөгийн Турк) хийгээд Урмиа нуурын (өнөөгийн Иран) хөндийг дамнан өндөрлөх нуруу (5200 м.өндөр) бөгөөд армянчуудын хувьд Масис гэж нэрлэгдэх ариун дагшин газар бөгөөд үндэсний бэлэг тэмдэг нь юм.

Селжүкийн эрхшээлд орж байсан байна. Үүний дараа армянчуудын түүхнээ монголчуудын үе эхэлдэг болно.

Армян түүх бичлэгийн оргил болсон 2 үе байдаг. Нэг нь өөрийн бичиг үсэгтэй болсон V зуун буюу орчуулгын зуун. Энэ үед армян хэлнээ Библи судар хийгээд философийн олон бүтээл грек, копт, хибру буюу еврей хэлнээс орчуулагдаж эхэлсэн³. Өөрөөр хэлбэл армянчууд эртний дэлхийн шинжлэх ухааны ололт амжилттай өөрийн хэлээр танилцаж эхэлсэн зуун юм. Нөгөө нэг оргил үе бол XIII-XIV зуун⁴. Энэ үед гарсан монголчуудын тухай армян түүх бичлэгийн бүтээлүүд тоо хийгээд төрөл жанраараа анхаарал татах бөгөөд XIX зуунд анхлан франц эрдэмтэд, дараа нь оросын, улмаар зөвлөлтийн эрдэмтэд орчуулж, тайлбар хийх, эмхэтгэх ажлыг хийсэн болно. 1980-д оноос монголчуудын тухай армян сурвалжууд англи хэлнээ орчуулагдах болов⁵.

³ Тэд өөрийн бичиг үсэгтэй болохоос өмнө эртний пахлави хэлээр уншиж бичиж байжээ. Армянчууд 301 (313?) онд Тиридат хааны үед Ортодокс буюу Үнэн алдартны Христос шашинд орсноор Ромчуудаас өмнө дэлхийн анхны загалмайтаны улс үндэстэн болжээ. Тэр үед Библи судрыг хибру (Hebrew) хэлнээс зөвхөн сири (Syriac), латин, копт (Coptic), абиссин хэлнээ хөрвүүлсэн байжээ. Армян мэргэд ийнхүү нутагтаа буцан ирж өөрийн бичгээ зохиосон түүхтэй. Армян цагаан толгой грек цагаан толгойг үндэс болгон авсан 36 үсэгтэй хийгээд армян хэлний авиан зүйн онцлогийг гаргах үүднээс дундад зуунд “о, ф” гэсэн 2 авиа тусгайлсан үсэгтэй болж нэмэгджээ.

⁴ V зууны армяны түүх бичлэгийг сонгодог үе гэж үздэг нь тухайн үед армянчуудын бичиж үлдээсэн түүхийн бүтээл арвин байснаас гадна, армян бичгийн хэл нийгмийн хэрэгцээг хангасантай холбоотой юм. Энэ үед гарсан Армяны түүхчдээс Павстос Бюзандаци, Газар Парпеци, Мовсес Хоренаци, Корьюн нарын бичсэн түүхийн бүтээлүүд Армяны түүхэн бичлэгийн эхийг хатгаж, араасаа үе үеийн түүхчдийг төрүүлсээр XIII зуунтай золгожээ. Армяны түүх бичлэгт зуун болгонд сайндаа 2-3 түүхч төрдөг байсан бол XIII зуунд 10 гаруй түүхч зохиолоо бичиж, бидэнд чухал тэмдэглэл, мэдээллийг үлдээсэн байна. Ийм үзэгдэл Перс сурвалжид ч мөн хамааралтай. Үүнийг эрдэмтэд тайлах оролдлого хийсэн боловч тогтсон хариу байдаггүй. Монголын эзэнт гүрний өөрийн онцлогийн нэг юм байх гэж үзүүштэй. 13-14 дугаар зууны Персийн түүх бичлэг урьд байгаагүй хөгжилдөө хүрсэн гэж хэлж болно. Үүнд, Жувейни, Рашид-ад-Дин, Жузжани, Вассаф, Кашани, Газвини зэрэг олон түүхч ар араасаа төрөн гарч түүхийн туурвилаа бичиж үлдээсэнтэй холбоотой.

⁵ Bayarsaikhan Dashdondog, *The Mongols and the Armenians* (1220-1335), 2011:3-6, 11 үзнэ үү. 1961 онд К.Мелик-Оханжаниян бүтээлийн бүрэн шүүмжлэлт редакцийг хийж хэвлүүлсэн. Ө.Дюлориер (E. Dulaurier) 1858 онд хэсэгчилэн франц хэлнээ орчуулсан, М.Вроссэ (M. Brosset) 1870 онд франц хэлнээ бүрэн бус орчуулга хийсэн. 1946 онд Тэр-Григорян, 1976 онд А.Ханларян орос хэлнээ орчуулсан хэдий ч бас бүрэн бус. 1975 онд Р.Бедросян англи хэлнээ орчуулсан ба зарим хэсгүүдийг алгасаад орчуулсан байдаг.

XIII зуун армян түүх бичлэгийн онцгой үе болохыг сурвалжийн төрөл жанраас харж болно. Үүнд түүхийн бүтээлүүд, он цагийн товчоон тэмдэглэлүүд, гэгээнтний намтар, бүтээлийн төгсгөлийн үгс, чулуун дээрх бичээс, яруу найраг зэрэг олон төрлөөр бичсэн сурвалжууд хамрагдана.

Түүхэн бүтээлүүд дотор Киракос, Вардан, Григор, Степпанос зэрэг лам нарын бүтээлийг онцолж болно. Тус бүрийн тухай товч тайлбар хэлье. Киракос Гандзакецийн *Армянчуудын түүх* (*Patmut'wn Hayots'*) хэмээх бүтээл нь 65 бүлэгтэй, армянчууд христийн шашинд орсноос эхлээд 1267 он хүртэлх түүхийг өгүүлэхдээ XI бүлгээс эхлэн монголчуудын тухай тодорхой мэдээ үлдээсэн байдаг. Армяныг дайлсан монголчуудын хоёрдугаар давалгаа буюу 1236 онд Киракос өөрийн багш Вардан Ванаканы хамт монгол ноён Моларт баригдсан юм. Ванакан багш нас өндөр байсан учир нутгийн ард 80 мөнгөн зоосоор түүнийг худалдан авч шоронгоос сулласан тул Киракос ганцаараа монголчуудад бүтэн жил зүтгэсэн байна⁶. Молар ноён Киракосын хэлний авьяасыг үнэлэн өөрийн бичиг хэргийн ажилд зүтгүүлэн орчуулга хийлгэж, тусгай гэр бариулж, эхнэр хүүхэд байгаа бол авчруулах зөвшөөрөл өгсөн байдаг⁷. Сүмийн лам байсан түүнд гэр бүл байгаагүй нь мэдээж. Молор ноён Армянаас Иран руу нүүх тушаал авсныг ашиглан нэгэн шөнө Киракос зугтан монголчуудаас салж сүм хийдээр нуугдан 1271 он хүртэл амьд явсан ба монголчуудын тухай өөрийн хувийн туршлага дээрээ тулгуурлан Армянд ирсэн эхний монголчуудаас авхуулан ил-хаадын үеийг оролцуулсан түүхийг бичсэн байдаг. Киракос өөрийн бүтээлдээ 70-аад монгол үгийн армян орчуулгыг хадаж өгснөөрөө анхны армян-монгол толь бичгийг үйлджээ⁸. Түүний сурвалж итгэл үзүүлэх шалгуурыг давсан бүтээл болсон гэж үзэж болно, учир нь монголын байлдан дагуулал, монголчуудын шашин шүтлэг, зан авир, тэдний зэрлэг бүдүүлгийн зэрэгцээ хүнлэг, шударга зан чанар аль алиныг өгүүлсэн байдаг⁹. Бүтээл 1266 онд болсон Жүчийн улсын Бэрх, ил-хаан Абага нарын тэмцлийг өгүүлж байгаад гэнэт дуусдаг. Үүнээс хойших 4 жилийн түүх бичигдээгүй үлдэв үү, алга болсон уу гэдэг нь тодорхой бус.

⁶ Киракос Гандзакеци, 1961: 244-252.

⁷ Мөн тэнд, 1961: 252.

⁸ Мөн тэнд, 1961: 271-275.

⁹ Киракосын монголчуудын дунд байсан талаар Dashdondog Bayarsaikhan, "Kirakos Gandzakets'i, a Mongol prisoner" *Ming Qing Yanjiu* 22 (2018): 155-163, өгүүлийг үзнэ үү.

Алга болсон уу гэж хэлдгийн учир дараагийн түүхчийн бүтээлтэй холбоотой. Учир нь зүүн нутгийн Вардан буюу Вардан Аревелци болон Киракос хоёр нэг багшийн шавь нар юм. Варданы бичсэн *Ертөнцийн түүх* (*Hawak'umn Patmut'ean*) нь сүүл хэсэгтээ монголчуудыг үеийг мөн хамардаг¹⁰. Тэрбээр монголчуудын Кавказ хийгээд Армяны нутагт цөмрөн орох үйл явцыг биеэр үзсэн бөгөөд зарим монгол ноёд, хаадтай биеэр уулзаж байсан болно.

Бичлэгийн хувьд он дарааллыг баримталсан ба монголчуудын талаар шашны зүтгэлтэн хүний нүдээр харж бичсэн байдаг. Вардан Их Армянаас гадна Иерусалем орсон ба Киликийн Армянд 5 жил амьдрах зуураа монголчуудын хөлд армянчуудын нутаг хэрхэн цөлмөгдөж байгааг хараад армянчууд бидний хийсэн нүгэл тун ихийн улмаас ийм зовлон үзэж байна хэмээн Их Армяны дээд хамба буюу Католикосд 1246 онд захиа бичиж санваартан олны гарын үсэг цуглуулж байжээ. Уг захидалд нүглээ наманчлах 25 зүүлт заалтыг оруулсан байдаг¹¹. Мөн түүнчлэн монголчуудын учруулсан зовлон Ертөнцийн эзний хүүгийн талаарх Ромын Католик сүм болон Армяны Апостолик сүм хоорондын маргаанаас болж байгаа гэж үзээд Католик сүмийн дээд чуулганд захидал бичсэн байдаг¹².

Вардан монголчуудын түүхийг 1220 оноос эхлүүлэн ил-хаадын үе хүртэл бичихдээ 1264 онд Табриз орж, Хүлэгү болон Докуз хатантай уулзсан уулзалтаа бахархан бичиж христчүүдийг ивээлдээ авсан хаан хатан гэж тодорхойлжээ¹³. Мөн Хүлэгүд илгээгдсэн хэдий ч Абага ил-хааны хатан болсон Мария Деспина хэмээх Византийн гүнжийн талаар бас бичсэн байдаг¹⁴. Энэ хүрээд түүний түүх нэг хэсэгтээ завсарладаг. Учир нь түүний гар бичмэлийн эх алдагдаж түүхчийн хамаатан залуу гар бичмэлийг Тифлисийн зах дээрээс 18 сарын дараа олжээ.¹⁵ Үүнээс хойш Вардан хэдэн хуудас нэмж бичээд 1267 оноор түүхээ дуусгаад дахин бичээгүй болно.

¹⁰ Эл сурвалжийн талаар Э.Баттүвшин “Армяны түүхч Варданы сурвалжид монголчуудын тухай өгүүлсэн нь” 2018 оны дипломын ажлыг үзнэ үү.

¹¹ Vardan Arevelts'i, 1991, 148; Kirakos Gandzakets'i, 1961, 310-311.

¹² Vardan Arevelts'i, 1991, 148. Дэлгэрэнгүйг Bayarsaikhan Dashdondog, *The Mongols and the Armenians* (1220-1335), 2011: 14-ээс үзнэ үү.

¹³ Мөн тэнд; Vardan Arevelts'i, 1991, 149-50, 157-61.

¹⁴ Мөн тэнд; 161.

¹⁵ Thomson, Vardan Arevelts'i, 1991, 9; Bayarsaikhan Dashdondog, *The Mongols and the Armenians* (1220-1335), 2011: 14-15.

Дараагийн сурвалж Григор Акнерцийн *Нум сумтан ард түмний түүх* (*Patmut'iwn vasn Azgin Netoghats*) бүтээл юм. “*Нум сумтан ард түмний түүх*”-ийн зохиогч нэрээ тодорхой дурдаагүй ч гар бичмэлийн эцэст “бидний багш таалал төгсөж Христос лугаа халихад олон шавьдаа захиас болгож...” гэж бичсэнээс нь Ванаканы шавь бичжээ гэсэн дүгнэлт хийдэг.

Түүхийг бичигч хэн болох талаар олон жил маргасаар иржээ. Вардан түүхч, Магакия Абега, Григор Акнерци гэсэн 3 хүний нэр үүнд холбоотой. Вардан байх үндэслэлийг Иерусалемийн гар бичмэлийн эхэнд бичсэнээр гаргажээ¹⁶. Харин Венецийн гар бичмэлд Магакия Абега буюу Магакия хутагт хэмээсэн байдаг¹⁷. 1974 онд Н.А.Погарян эл маргааны ацыг хагалан хэл найруулга, он тоолол, түүхэн цаг хугацааны үүднээс Магакия хутагт болон Вардан түүхчийн нэр энэхүү сурвалжид огт холбогдолгүй хийгээд хуулан бичигчдийн нэмэлт оруулгаас гарсан төөрөгдөл болохыг нотолжээ¹⁸. Иерусалемд хэвлэгдсэн “*Нум сумтан ард түмний түүх*”-ийн эхийн аль ч хэсэгт нь Магакиягийн нэр тохиолдохгүй бөгөөд харин төгсгөлийн үгэнд буй мэдээнд “энэхүү түүх нь 720 (1271) онд Акнер (Акан) сүмийн тэргүүн хүндэт эцэг Степаносын зарлиг болон тус сүмийн нярав Вардан ба бүх санваартнуудын соёрхлоор золгүй Григор бичив” хэмээх мөрүүдээс сурвалжийн зохиогч Григори болох нь тодорхой болжээ. Ийнхүү судалгааны үр дүнд “*Нум сумтан ард түмний түүх*” хэмээх энэхүү сурвалжийг бичигч нь дээр дурдсан зохиогчийн тухай таамгийн гурав дахь нэртэй холбогдож, Газар дундын тэнгисийн армянчуудын нутаг болох Киликийн Акнер сүмийн лам Григор болох нь тогтоогдсон юм. Армяны түүхийн сурвалжууд Ертөнцийн үүслээс эхэлдэг бол эл зохиол тэднээс ялгарч Абраамын удам судрын товч мэдээллийг эс тооцвол, Чингис хаан ширээнд заларснаас хойш 1271/1273 он хүртэлх Армяны түүхийг өгүүлдэг¹⁹. Гол тэмдэглэл нь XIII зууны Киликийн ба Кавказын Армянд өрнөж буй түүх юм²⁰.

Энэ сурвалжтай холбогдох нэгэн дорвитой бүтээл бол нэрт монгол судлаач Ф.Клийвзийн “Григор Акнерцийн бичсэн “*Нум сумтан ард*

¹⁶ Погарян, 1974: 5-7, Blake & Frye, 1954: 271.

¹⁷ Сурвалж нь зохиогчийн нэрийн будлианаас болж Магакия хутагт бичсэн хэмээн олон жил үзсээр ирсэн ба орос хийгээд франц орчуулга энэхүү нэрээр орчуулагджээ.

¹⁸ Погарян, 1974: 5-11.

¹⁹ Grigor Aknerts'i, 1974: 28, 36.

²⁰ Эл сурвалжийн эх болон орчуулгыг *Нум сумтан ард түмний түүх*, Антон Мостаэртын Монгол судлалын төв, Улаанбаатар, 2010-с үзнэ үү.

түмний түүх” сурвалж дахь монгол нэр, томьёонууд” хэмээх томоохон хэмжээний өгүүлэл бөгөөд үүнд 43 монгол хүний нэр, засаг захиргаа, хууль цааз, татвар, цэргийн зохион байгуулалтад холбогдох 9 монгол үгсийг хэл шинжлэлийн үүднээс дэлгэрэнгүй судлан үнэлэлт дүгнэлт өгсөн юм²¹.

Степанос Орбелианы *Сисак мужийн түүх (Patmut'iwn Nahangin Sisakan)* хэмээх бүтээл нь дэлхий үүссэнээс эхлээд 1299 он хүртэлх түүх бөгөөд 73 бүлэгтэй, 66-р бүлгээс эхлэн монголчуудын тухай өгүүлдэг. Энэ түүх бол ил-хаадын түүх бөгөөд Сисак мужийн Орбелийн гэр бүл монголчуудтай харьцаж байсан тухай юм²². Степанос өөрөө Аргун, Гейхату, Газан ил-хаадтай уулзаж өөрийн өрсөлдөгч армян гэр бүлийнхнээс монгол хаадын тусламжтайгаар газар нутгаа тэлэх бодлого явуулж байжээ. Угтаа Орбелийн гэр бүлийнхнийг магтах гэсэн санаа өвөрлөн монголчуудын итгэлийг хэрхэн олж байсан тухайгаа бичсэн юм. Цэрэг дайны үйл ажиллагаанаас гадна монголчуудын цэнгүүнд бөх барилдуулж, барилдсан бөх нь монгол бөхийг давж байсан²³ зэрэг бусад сурвалжид байхгүй мэдээгээр арвин сурвалж юм.

Он дарааллын товчоон, тэмдэглэлүүд, гэгээнтний намтрууд, бүтээлийн төгсгөлийн үгс, чулуун дээрх бичээс, яруу найраг зэрэг олон төрлийн сурвалжууд байдаг²⁴.

XIII зуунд гарсан армян сурвалжийн төрөл хийгээд тооны талаар онцгой байгааг тайлбарлах хэдэн үндэслэл байж болох юм. Тухайн үед монголчуудад баригдаад нутгийн ард 80 мөнгөн зоосоор худалдаж авсан Ванакан багш өөрөө түүхч байсан ба олон шавь нартаа түүхээ бичих даалгавар өгдөг байжээ. Иймд Киракос, Вардан, Григор нар бүгд энэ хүний шавь нар, бүгд өөр өөрийн түүхийг бичсэн байна. Түүхчид бүгд лам байсан, иймд монголчууд сүм хийд болон лам нарыг ивээлдээ авч байсны улмаас тэд бүтээлээ бичих эрх чөлөөг эдэлж байжээ.

Түүхчид зөвхөн Их армяны түүхчид байсангүй, мөн Киликийн армяны түүхчид бүтээлээ бичиж үлдээсэн байдаг. Монголчууд бичгийн хүмүүсийг ашиглах үүднээс тэднийг тэтгэдэг байсан. Учир нь монголчуудад нутгийн боловсролтой хүмүүсийн шаардлага байсны

²¹ F.Cleaves “Mongolian Names and Terms in *The History of The Nation of The Archers* by Grigor of Akanc” *Harvard Journal of Asiatic Studies*, Vol. 12, (3/4), (1949): 400-443.

²² Step'annos Orbelian, 1910, 410-20.

²³ Мөн тэнд, 482-83.

²⁴ Дэлгэрэнгүйг Bayarsaikhan Dashdondog, *The Mongols and the Armenians* (1220-1335), 2011: 10-26-с үзнэ үү.

улмаас тэднийг үнэлж шашнаар түрэмгийлэх бодлого явуулаагүй байсны улмаас бичсэн зүйлийг нь устгадаггүй, иймд армян түүх бичлэг арвижиж байжээ гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Эцэст нь өөр нэг чухал гэхдээ адармаатай сурвалжийг танилцуулъя. Энэ бол Хетум Корикос буюу түүхч Хетумын (Het'um Patmich') бүтээл болно. Адармаатай гэдгийн учир нь нэрээсээ авхуулаад бөөн будлиан үүсгэдэг. Дундад зууны армянчуудын дунд Хетум нэр их түгсэн байдаг. I Хетум, II Хетум гэсэн хаад бий, тэд бас түүх буюу он цагийн товчооноо үлдээсэн байдаг. Иймд Хетум түүхчийг барууны эрдэмтдийн нэршсэнээр Хайтон нэрээр нь авч үзье.

Түүний бичсэн түүх нь *Дорнын түүхийн цэцгийн баглаа* (*La Flor des Estoires de la Terre d'Orient*) нэртэй, 1307 онд франц хэлээр бичигдсэн, 1842 онд армян хэлнээ орчуулсан бүтээл юм. Иймд армян сурвалж уу, франц сурвалж уу гэсэн будлиан үүсдэг. Хайтон нь I Хетум хааны ахынх нь хүү, 1280 оны үед Корикос нутгийн эзэн суусан. Энэ бүтээл нь өөрийн амьдралыг тусгасан ба хоёр ил-хаадын хаан ор суух ёслолд оролцсон хэмээн дурджээ²⁵. 1293 онд Хетум хааныг зайлуулах нууц хуйвалдаанд оролцсоны улмаас Кипр рүү зугтав гэсэн мэдээ нь түүний 1306 онд Пап ламтай уулзахаар Парис очсон, Армяны хааныг дэмжихийг уриалан *Цэцгийн баглаа*-гаа бичих болсон зэрэг мэдээтэй уялдаж өгдөггүй талтай.

Гэхдээ энэ сурвалж өрнөдөд маш их түгсэн, тэр бүү хэл их алдартай болсон бүтээл юм. Өрнийн загалмайтнууд, Пап ламын дипломат үйл ажиллагаа хийгээд христ армянчуудын түүх бичлэгт онцгой байр суурь эзэлдэг. Бичигдсэн 1307 ондоо Латин хэлнээ орчуулагдаж, XIV зууны сүүлийн хагаст Испани хэлнээ орчуулагдаж, 1351 онд дахин франц хэлнээ Ж.Лонгийн орчуулгаар гарсан байна. 1520-иод оноос эхлэн англи хэлнээ 2 удаа, улмаар Герман, Итали, Дани хэлнээ орчуулагджээ²⁶.

Эл сурвалж ижил бус 4 хэсгээс бүрдэнэ. Нэгдүгээр боть Ази тивийн газарзүй болон түүхийг өгүүлнэ. Хоёрдугаар боть *Сарацины* эзэд нэртэй хийгээд VII зууны Исламын байлдан дагуулын тухай өгүүлдэг. Гуравдугаар буюу хамгийн том хэмжээний боть нь монголчуудын түүх, монголын байлдан дагууллыг өгүүлдэг. Дөрөвдүгээр ботийн гол санаа нь Христийн ертөнц ба Монголын эзэнт гүрний хооронд санал болгож буй хамтын ажиллагааны тухай бөгөөд Иерусалемыг чөлөөлөх загалмайтнуудын аян дайны төгсгөлийн тухай өгүүлдэг. Хайтон

²⁵ Het'um Patmich', 1951: 33.

²⁶ Bayarsaikhan Dashdondog, *The Mongols and the Armenians* (1220-1335), 2011: 21-26.

бүтээлийн эх сурвалждаа Мөнх хаан хүртэлх өрнийн сурвалжуудыг дурдсан ба 1250 хойших түүхнээ I Хетум хааны өөрийн өгүүлэмжийг ашигласан гэдгээ тэмдэглэжээ²⁷.

Энэхүү сүүлийн ботид дурдагдсан Мөнх хаан хийгээд I Хетум хааны хооронд байгуулсан гэрээний асуудлаар энэ сурвалжийг эргэлзээтэй сурвалжийн тоонд оруулж армянчуудын цэвэр *фантази* хэмээн судлаач Д.Банди, П.Жексон нар үзээд Латин-Монгол-Армяны хамтын ажиллагааг эхлүүлэх гэсэн оролдлогодоо монголчуудыг татан оролцуулахыг Пап ламд уриалсан бүтээл гэж дүгнэжээ²⁸. Гэсэн хэр нь дундад зууны армян түүх бичлэгийн боловсронгуй бүтээл гэж тодорхойлсон байдаг²⁹.

Энэ сурвалжийн талаарх өөрийн үнэлгээг өгвөөс хэдийгээр энэ сурвалжийн бичсэн зорилго нь тусгай, өөрөөр хэлбэл Латин ертөнцийг монголчуудтай хамтран исламын эсрэг тэмцэхийг уриалсан боловч *Цэцгийн баглаа* нь монголчуудын тухай дундад зууны армян сурвалж мөнөөс мөн. Он цагийн хийгээд зарим жижиг алдааг эс тооцвоос түүхийн өгүүлэмжийн хувьд маш цэгцтэй бүтээл. Үүнд:

1. Монгол-Армяны харилцааг судлахад;
2. Христчүүдийн ариун дагшин газраа исламынхнаас чөлөөлөхөд Латин ертөнцийн ганц гарц нь монголчууд болох;
3. Мөнх хааны ордонд болж байсан түүх давтагддаг, тухайлбал Мөнхийг христ ёсоор адислах гэсэн оролдлого бусад өрнийн сурвалжид дурдагддаг;
4. Гэрээний 7 нөхцөл зэрэг нь түүхнээ хожим тусгалаа олсон зүйл болох үүднээсээ үнэ цэнтэй сурвалж хэмээн үзэж байна³⁰.

Монгол-Армяны гэрээ байсан тухай тухайн үеийн армян сурвалжид, тухайлбал Киракос, Варданы түүхэнд халт боловч дурдагдсан байдаг. Судлаачдаас Микаелян, Галстян нар гэрээ байсан гэдгийг дэмждэг³¹.

Гэрээний биелэлтийн талаар дурдахад 1256 онд I Хетум хаан Монголоос буцаж ирээд ил-хаадтай шууд харилцан өөрийн нутгаа Селжүкүдээс монголчуудын хүчээр буцаан авсан. Латин-монголын хамтын ажиллагааг эхлүүлэх оролдлогодоо Антиохийн Бохемундыг ятгаад Дамаск руу Хүлэгүтэй хамт Бохемунд орж ялалтаа тэмдэглэсэн.

²⁷ Het'um Patmich', 1951: 33.

²⁸ Bundy, 1987: 223-35; Jackson, *The Mongols and the West*, 2005: 120-21.

²⁹ Bundy, 1987: 233.

³⁰ Bayarsaikhan Dashdondog, *The Mongols and the Armenians (1220-1335)*, 2011:23.

³¹ Mikaelean, 1952, 310-14; Galstyan, 1962, 124-26.

Монгол-Киликийн армяны цэргийн хамтын ажиллагаа урт удаан хугацаанд амжилттай явагдсан болно. Иймд хэдийгээр бичгээр үйлдсэн гэрээ олдоогүй ч Хетум түүхчийн бичсэн сурвалж тухайн бүс нутагт армянчууд монголчуудад хэрхэн хандаж байсныг тод харуулсан гэж үзэж байна.

Дүгнээд хэлэхэд Армяны түүх бичлэг арвин уламжлалтай. МЭ 406 оноос эхлэн өөрийн бичиг үсэгтэй болсон армянчууд түүх бичлэгээ нарийн нямбай хөтөлж иржээ. Ямартаа ч тэд өөрсдийн бичиг үсгээ дээдлэх үүднээс 1959 онд Армяны нийслэл Ереван хотноо эртний судар бичгийн номын өргөө болсон Месроп Маштоцын нэрэмжит Матенадараны өмнө Армян цагаан толгойн гантиг хөшөөг босгосон юм³². Хамгийн олзуурхууштай бөгөөд хачирхалтай нь XIII зуун бол Армяны түүх бичлэг хамгийн арвин үеийн нэг билээ. Монголын эзэнт гүрэн болон монголчуудын тухай армян сурвалжуудаас Самуэл Анеци, Мхитар Анеци, Матеос Урхаеци, Мхитар Айриванеци, Вардапет Ванакан, Киракос Ганзакеци, Вардан Айриванеци, Григор Акнерци, Степанос Орбелян, Степанос Епископос, Вахрам Рабуни, Смбат Спарамет, Хетум Патмич (Hayton) нарын бичсэн түүх болон нэр нь тодорхойгүй олон түүхчийн он цагийн бичгүүдийг нэрлэхэд хангалттай.

Монголчуудын тухай Армян сурвалжууд нь Монголын байлдан дагуулал, монголчуудын нийгэм, цэргийн зохион байгуулалт, зан араншин, эдлэл өмсгөл, зүс царай, ёс суртахуун, үг хэл зэрэг олон талын чухал мэдээлэл агуулдаг билээ. Дээр товч дурдсан армян сурвалжууд үнэ цэнийн хувьд адилгүй боловч, Монгол судлал хийгээд Монголын эзэнт гүрний судалгаанд өөрийн хувь нэмрийг оруулах тус тус давтагдашгүй дурсгал гэдэг нь дамжиггүй.

³² Армяны шашны төв болох Эчмиадины номын санд байсан судар бичгийн арвин цуглуулгыг 1920 онд улаан большевикууд хураан авч Москва руу илгээснийг 1922 онд Армян руу буцаан ирүүлжээ. Үүнд Армян гаралтай ардын комиссариатын дарга асан Александр Миасникяны үүрэг их байсан ажээ. Судар бичгийн дурсгалууд сүйрлээс аврагдан 1929 онд төрийн өмчийн бүртгэлд орж, 1939 онд Александр Миасникяны нэрэмжит номын сангийн хөмрөгт шилжин, 1959 оны Армяны Сайд нарын Зөвлөлийн тогтоолоор Судрын Өргөө буюу Матенадаран хэмээх тусгайлан барьсан ордонд байрлалаа олжээ. 1962 онд тэрхүү өргөө Армян цагаан толгойг бүтээсэн Месроп Маштоцын нэрэмжит болсон байна.

Ном зүй

Bayarsaikhan Dashdondog, *The Mongols and the Armenians (1220-1335)*, 2011.

Баттүвшин Э., “Армяны түүхч Варданы сурвалжид монголчуудын тухай өгүүлсэн нь” 2018 оны дипломын ажил.

Bedrosian, R., “The Turco-Mongol Invasions and the Lords of Armenia in the 13-14th Centuries” (Ph.D diss., Columbia University, 1979).

Bundy, D., “Het‘um’s *La Flor des Estoires de La Terre d’Orient*”, *REA* 20 (1987): 223-35.

Cleaves, F., “Mongolian Names and Terms in *The History of The Nation of The Archers* by Grigor of Akanc’” *Harvard Journal of Asiatic Studies*, Vol. 12, (3/4), (1949): 400-443.

Dashdondog Bayarsaikhan, “Kirakos Gandzakets‘i, a Mongol prisoner” *Ming Qing Yanjiu* 22 (2018): 155-163.

Galstyan, A. G. (ed.), *Armjanskije Istochniki o Mongolakh*, (Armenian Sources for the Mongols), Moscow: VostochnajaLiteratura, 1962.

Galstyan, A., “The First Armeno-Mongol Negotiations”, *The Armenian Review* 29 (1976): 26-37.

Grigor Aknerts‘i /Grigor of Akanc‘(1250-1335), *History of the Tatars / History of the Nation of the Archers*, Jerusalem: St. Jacob Press, 1974. N. Pogharean, foreword in Grigor Aknerts‘i, 1974: 5-15.

---. *History of the Nation of the Archers* (1271/73), R.P. Frye and R. N Blake (trs. and eds.), Cambridge, Massachusetts: Harvard University Press, 1954.

---. *Нум сумтан ард түмний түүх*, Антон Мостаэртын Монгол судлалын төв, Улаанбаатар, 2010.

Hakobyan, V.A. (ed.), *Minor Chronicles of the 13th-18th centuries*, vol. 1, Erevan: Academy of Sciences Press, 1951, vol. 2, Erevan: Academy of Sciences Press, 1956.

Hayton/ Hethum/ Hetoum/ Het‘um/ Het‘um Patmich‘/Het‘um of Korikos (d. 1311?), “La Flor des Estoires de la Terre d’Orient” in E. Dulaurier (ed.), *RHC / DA*, Paris: Académie des Inscriptions et Belles-Lettres, 1869.

Hewsen, R., “The Geography of Armenia” in R. Hovannisian (ed.), *The Armenian People from Ancient to Modern Times*, vol. 1, London: Macmillan, 1997: 1-17.

Jackson, P., *The Mongols and the West, 1221-1410*, London: Pearson /Longman, 2005.

Kirakos Gandzakets‘i (1200-1271), *History of the Armenians*, Melik‘-Ohanjanyan (ed.), Erevan: Academy of Sciences Press, 1961.

Mikaelean, G., *Istoriija Kilikiiskogo Armjanskogo gosudarstva* (History of Cilician Armenian Kingdom), Erevan: Academy of Sciences Press, 1952.

Sanjian, Avedis K. (tr.), *Colophons of Armenian Manuscripts (1301-1480)*, Cambridge, Massachusetts: Harvard University Press, 1969.

Step‘annos Orbelian (1250/60-1304), *History of Siwnik Province*, K. Shahnazareants‘ (ed.), Paris: 1860; T‘iflis: 1910.

Strabo, *The Geography*, tr. by H. L. Jones, London: William Heinemann Ltd, 1969.

Vardan Arevelts‘i (ca.1200 -1271), *Universal History*, completed in 1267, G. B. T‘osunyan (ed.), Erevan: Erevan University Press, 2001.

---. *Chronicle*, int. by R. W. Thomson, Delmar, New York: Caravan Books, 1991.